



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 438

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хавсралтад заасан 117,181,818.18 (нэг зуун арван долоон сая нэг зуун наян нэгэн мянга найман зуун арван найман төгрөг арван найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Ховд-А33А” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.“Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Хаянхярваа, “Ховд-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Батцагаан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, автомашины улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчөөс бүртгэлээс хассан тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001388

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

2021 оны 10 дугаар сарын 29 өдрийн

438 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

д/д	Автомашины нэр, улс, арлын дугаар	Ашиглал тад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Ашиглах хугацаа (жил)
1	Ниссан Патрол Y-62, 06-98 УБУ, суудлын, арал- JN1TANY62Z0000232	2010	117,181,818.18	"Ховд-А33А" ТӨХК	3,000,000.00	2
			117,181,818.18		3,000,000.00	
	Нийт дүн		(нэг зуун арван долоон сая нэг зуун наян нэгэн мянга найман зуун арван найман төгрөг арван найман мөнгө)		(гурван сая)	